



2018 оны 10 дугаар сарын 22
№39/1044/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
Их Хурлын
тогтоол**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт**

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилох тухай**

**Сангийн дүрэм, зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай**

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох
хэсгийг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

355. Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Дугаар 74 1213

356. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай Дугаар 75 1214

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

357. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 136 1214

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

358. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 173 1215

359. Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Дугаар 179 1224

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

360. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 11 1231

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 10 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.2} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Жадамбын Бат-Эрдэнийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2018 оны 10 дугаар
сарын 05-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдаар Янгугийн Содбаатарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 10 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 136

Улаанбаатар
хот

**Шүүгчийн албан тушаалаас
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бадамдоржийн Саранчимэгийг Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 6.1.6, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 151 дүгээр зарлигийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Олон улсын олимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ц.ЦОГЗОЛМАА

Засгийн газрын 2018 оны 173 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**ОЛОН УЛСЫН ОЛИМПЫН ХОРООНЫ ИВЭЭЛ ДООР ЗОХИОН
БАЙГУУЛАГДДАГ ТИВ, ДЭЛХИЙН НААДАМ БОЛОН ДЭЛХИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦОЖ
МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ТҮҮНИЙ ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ
ШАГНАЖ УРАМШУУЛАХ, МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Олон Улсын Олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн наадам болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлөн амжилттай оролцсон тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнах, урамшуулах харилцааг энэ журмаар зохицуулна.



1.2. Мөнгөн шагнал, урамшууллыг дараах байдлаар олгоно:

1.2.1. энэ журмын 1.1 дэх хэсэгт заасан тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдад нэг удаагийн мөнгөн шагнал олгоно;

1.2.2. үе үеийн олимпын наадам (зуны олимп, өвлийн олимп, паралимпын наадам), дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс олимпын жин, зайд медаль хүртсэн Монгол Улсын иргэнд насан туршид нь сар бүр мөнгөн урамшуулал олгоно.

1.3. Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг тив, дэлхийн хэмжээний спортын наадам, Дэлхийн допингийн эсрэг агентлагаас хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын спортын холбооны зохион байгуулсан тэмцээн гэж дараах тэмцээн, наадмыг ойлгоно:

1.3.1. “спортын наадам” гэж Олон улсын олимпын хорооны ивээл доор зохион байгуулагддаг Олимп, Паралимп, Дифлимп, Өсвөр үеийн Олимп, Универсиад, Тусгай Олимп, Дэлхийн наадмыг;

1.3.2. “Азийн наадам” гэж Азийн олимпын зөвлөлийн ивээл доор зохион байгуулагддаг Азийн танхимын, тулааны, элсний наадмыг;

1.3.3. “Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн” гэж Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн олон улсын спортын холбооноос зохион байгуулагддаг спортын тэмцээнийг;

1.3.4. “Олимпын наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн” гэж Олон улсын Олимпын хороо болон Азийн олимпын зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн спортын төрлийн олон улсын холбооноос зохион байгуулагддаг Олимпын бус төрлийн тэмцээнийг.

Хоёр. Тамирчинд мөнгөн шагнал олгох

2.1. Журмын 1.3-т заасан тэмцээн, наадамд амжилттай оролцсон тамирчин, түүний дасгалжуулагчдад спортын тэмцээн, наадмын ангилал, тэмцээнд оролцсон тивийн төлөөлөл, тухайн жин, зайд оролцсон орны өрсөлдөгч тамирчны тооноос хамааран доор дурдсан хувь, хэмжээгээр мөнгөн шагнал олгоно:



Мөнгөн шагнал тооцох хувь

Тэмцээн	Тивүүдийн оролцоо, хувь хэмжээ		Жин, зай тус бүрт оролцсон орны тоо		Мөнгөн шагналын хувь
	Оролцсон тивүүдийн тоо	Мөнгөн шагналын хувь	Эрэгтэй	Эмэгтэй	
Олимп	Оролцогч орны тоо, тивийн төлөөлөл харгалзахгүй				100
Паралимп					
Өсвөр үеийн Олимп					
Дифлимп					
Универсиад, Дэлхийн наадам, Тусгай Олимп	4-5	100	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100
	3 хүртэлх	80	21-31	17-23	60
			20 хүртэлх	16 хүртэлх	30
Азийн наадам	Тивийн төлөөлөл харгалзахгүй		24 болон түүнээс дээш	16 болон түүнээс дээш	100
			16-23	12-15	60
			15 хүртэлх	11 хүртэлх	30
Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлүүдийн Дэлхийн аварга	4-5	100	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100
	3 хүртэлх	80	21-31	17-23	60
			20 хүртэлх	16 хүртэлх	30
Олимпын наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлийн Дэлхийн аварга	4-5	100	32 болон түүнээс дээш	24 болон түүнээс дээш	100
	3 хүртэлх	80	21-31	17-23	60
			20 хүртэлх	16 хүртэлх	30



Тамирчинд олгох мөнгөн шагналын хэмжээ

Д/д	Наадам, тэмцээний ангилал, оноосон нэр	Мөнгөн шагналын хэмжээ (сая.төг) (Тамирчдын насны ангилал, медалиар)								
		Насанд хүрэгчид			Залуучууд			Өсвөр үе		
		Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл	Алт	Мөнгө	Хүрэл
1.	Олимпын наадам	120.0	60.0	30.0	-	-	-	40.0	20.0	10.0
	Паралимпын наадам	120.0	60.0	30.0	-	-	-	-	-	-
	Дифлимпын наадам	60.0	30.0	10.0	-	-	-	-	-	-
	Универсиад	-	-	-	30.0	15.0	10.0	-	-	-
	Дэлхийн спортын наадам	15.0	8.0	4.0	-	-	-	-	-	-
	Дэлхийн оюуны наадам, Дэлхийн тулааны наадам	10.0	6.0	3.0	-	-	-	-	-	-
	Азийн наадам	30.0	15.0	10.0	-	-	-	7.0	5.0	4.0
	Азийн элсний, танхимын, тулааны наадам	8.0	4.0	2.0	-	-	-	-	-	-
2.	Олимпын наадмын хөтөлбөрт багтдаг спортын төрлийн Дэлхийн аварга	40.0	25.0	20.0	15.0	10.0	8.0	7.0	5.0	4.0
3.	Олимпын наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлийн Дэлхийн аварга	10.0	7.0	5.0	7.0	5.0	3.0	4.0	3.0	2.0



2.2. Тамирчны оролцсон жин, зай тус бүрд авсан медальд, оролцсон спортын төрлийн тэмцээн нь олон төрлийн нийлбэр дүнгээр амжилтыг тооцож медаль олгодог бол зөвхөн нийлбэр дүнгийн медальд ногдох мөнгөн шагналыг тус тус олгоно.

2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан тэмцээний ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.4. Тусгай Олимпийн наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчинд энэ журмын 2.1-д заасан тамирчинд олгох мөнгөн шагналын хэмжээний олимпийн наадмын хөтөлбөрт багтдаггүй спортын төрлүүдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний өсвөр үеийн насны ангилалд ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.5. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн тамирчин тус бүрийн тэмцээний оролцооны статистикийг харгалзан доор дурдсан хувиар мөнгөн шагналыг олгоно:

Багийн гишүүн	Нийт оролцоонд хамаарах хувь	Олгох мөнгөн шагналын хувь
Тамирчин	50-аас дээш	100
	50-аас доош	50

2.6. Тамирчин шатар, зуун буудалт даамын төрлөөр олон улсын их мастер (Гроссмейстер)-ын цол хүртсэн бол Азийн наадмын алтан медальд ноогдох мөнгөн шагналыг нэг удаа олгоно.

2.7. Тамирчин хэмжигдэхүүнтэй спортын төрлөөр энэ журмын 2.1-д заасан ангиллын тэмцээнүүдэд оролцох үед тив, дэлхийн рекордыг шинэчлэн тогтоосон тохиолдолд тухайн тэмцээн, наадмын алтан медальд ногдох шагналын 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг тивийн оролцоо, оролцогч орны тоог харгалзахгүй олгоно.

Гурав. Дасгалжуулагчид олгох мөнгөн шагнал

3.1. Дасгалжуулагчид медаль хүртсэн тамирчинд олгох мөнгөн шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналыг олгоно.

3.2. Тамирчин нь тив, дэлхийн рекорд амжилт тогтоосон бол тамирчны мөнгөн шагналтай дүйцэх хэмжээний мөнгөн шагналыг дасгалжуулагчид олгоно.

3.3. Тамирчин болон багтай 1-ээс дээш дасгалжуулагч ажилласан тохиолдолд мөнгөн шагналыг хувь тохирсон гэрээний дагуу дасгалжуулагчид хувааж авна.



Дөрөв. Тамирчинд сар бүр олгох урамшуулал

4.1. Олимп, паралимп болон олимпийн наадмын төрөлд багтдаг спортын төрлийн зай, жинд Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний насанд хүрэгчдийн ангилал, зай, жинд Монгол Улсын нэрийн өмнөөс оролцож, медаль хүртсэн Монгол Улсын иргэнд насан туршид нь сар бүр мөнгөн урамшууллыг доор дурдсан хэмжээгээр олгоно.

Сар бүр олгох мөнгөн урамшууллын хэмжээ

Д/д	Тэмцээний нэр	Хүртсэн медаль	Урамшууллын хэмжээ (сая.төг)
1.	Олимпийн наадам (Зуны олимп, өвлийн олимп, зуны паралимп, өвлийн паралимп)	Алт	4.0
		Мөнгө	3.0
		Хүрэл	2.0
2.	Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн (Олимпийн наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлийн зай, жинд)	Алт	2.0
		Мөнгө	1.0
		Хүрэл	0.5

4.2. Гадаад улсын иргэн байх үедээ медаль хүртсэн тамирчинд сар бүрийн мөнгөн урамшууллыг олгохгүй.

4.3. Тамирчин нь сар бүрийн мөнгөн урамшуулал авах болзол хангасан бол мөнгөн урамшууллыг дараа оны төсвийн жилийн эхнээс эхэлж олгоно.

4.4. Тамирчин сар бүрийн мөнгөн урамшуулал авах болзол хангасан боловч урамшуулал олгогдохоос өмнө нас барсан тохиолдолд түүний ар гэрт нэг жилийн турш олговол зохих мөнгөн урамшуулалтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг нэг удаа олгоно.

4.5. Мөнгөн урамшуулал авч байсан тамирчин нас барсан тохиолдолд тухайн сараар дуусгавар болгож мөнгөн урамшууллыг зогсооно.

Тав. Мөнгөн шагналаар шагнах, мөнгөн урамшуулал олгоход тавих шаардлага

5.1. Мөнгөн шагналаар шагнуулах болзол хангасан тамирчин, дасгалжуулагчийн харъяалах спортын холбоо нь биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараах материалыг бүрдүүлэн тэмцээн дууссанаас хойш 30 хоногийн дотор ирүүлнэ:

5.1.1. тамирчин, дасгалжуулагчийг мөнгөн шагналаар шагнуулах тухай хүсэлт;



5.1.2. тэмцээний албан ёсны урилга, заавар;

5.1.3. тэмцээнд оролцох тамирчдын овог, нэр, нас, хүйс, оролцох зай, жинг тусгасан багийн бүрэлдэхүүнийг баталсан спортын холбооны шийдвэр;

5.1.4. тэмцээн, наадамд медаль авсныг нотолсон Олон улсын спортын холбооны албан ёсны протокол, дипломын хуулбар;

5.1.5. тухайн тэмцээний мэдээлэл, протоколыг байршуулсан албан ёсны цахим хаяг;

5.1.6. мөнгөн шагналыг шилжүүлэх банкны нэр, дансны болон регистрийн дугаар;

5.1.7. тамирчин болон багтай 1-ээс дээш дасгалжуулагч ажилласан бол мөнгөн шагналын хувь тохирсон гэрээ.

5.2. Тамирчин сар бүрийн мөнгөн урамшуулалд хамрагдахдаа дараах материалыг бүрдүүлэн Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ:

5.2.1. холбооны хүсэлт, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөл, тухайн тамирчин нас барсан бол эхнэр, нөхөр, хүүхэд, албан ёсны өв залгамжлагч болохыг нь нотлох бичиг баримт;

5.2.2. тамирчны амжилтыг гэрчлэх албан ёсны протокол, дипломын хуулбар;

5.2.3. мөнгөн урамшууллыг шилжүүлэх банкны нэр, дансны болон регистрийн дугаар.

5.3. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох материалыг хянаж, салбарын сайдын тушаалаар мөнгөн шагнал, сар бүрийн мөнгөн урамшууллыг олгоно.

5.4. Олимп, паралимпийн наадмаас медаль авснаас бусад тохиолдолд мөнгөн урамшууллыг улиралд нэг удаа олгоно.

5.5. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сар бүрийн мөнгөн урамшуулал авах тамирчдын нэрсийг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор шинэчлэн биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталж, мөнгийг сар бүрийн 25-ны өдрийн дотор тухайн тамирчны дансанд шилжүүлнэ.



5.6. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага медаль хүртсэн тамирчин, дасгалжуулагчийн талаарх мэдээллийн санг бүрдүүлж ажиллана.

5.7. Тамирчин допинг хэрэглэсэн нь тогтоогдож медалиа хураалгасан тохиолдолд мөнгөн шагнал, урамшууллыг олгохгүй бөгөөд олгосны дараа илэрвэл мөнгөн шагнал, урамшууллыг нөхөн төлүүлнэ.

Засгийн газрын 2018 оны 173 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

**ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ ТЭМЦЭЭН, НААДАМД АМЖИЛТТАЙ
ОРОЛЦОЖ МЕДАЛЬ ХҮРТСЭН ТАМИРЧИН, ТҮҮНИЙ
ДАСГАЛЖУУЛАГЧИЙГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ,
МӨНГӨН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын хэмжээнд зохион байгуулж байгаа Монголын бүх ард түмний спортын наадам, хүүхдийн, оюутны, үндэсний спортын наадам, Биеийн тамир, спортын тухай хуулийн дагуу эрх авсан спортын холбооноос зохион байгуулах улсын аварга шалгаруулах тэмцээн (цаашид “тэмцээн” гэх)-д амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг мөнгөн шагналаар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын хувь хэмжээ

2.1. Медаль хүртсэн тамирчинд доор дурдсан хэмжээний мөнгөн шагнал олгоно:

Д/д	Тэмцээний		Медалийн төрөл	Мөнгөн шагналын хэмжээ (мян.төг)
	Ангилал	Зэрэглэл		
1	Наадам	Монголын бүх ард түмний спортын их наадам	Алт	1,500.0
			Мөнгө	1,000.0
			Хүрэл	500.0
		Оюутны, Үндэсний, Хүүхдийн	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
2	Улсын аварга	Насанд хүрэгчид	Алт	600.0
			Мөнгө	400.0
			Хүрэл	200.0
		Залуучууд, Өсвөр үе	Алт	400.0
			Мөнгө	200.0
			Хүрэл	100.0

2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчид энэхүү журмын 2.1-ийн “наадам” ангилалд заасан мөнгөн шагналыг олгоно.

2.3. Багийн нийлбэр дүнгээр медаль хүртсэн бол багийн дасгалжуулагчид энэ журмын 2.1-д заасан тэмцээний ангиллын дагуу ногдох мөнгөн шагналыг олгоно.

2.4. Багийн спортын төрлөөр медаль хүртсэн тамирчин тус бүрийн тэмцээний турш талбайд тоглосон нийт хугацааны статистикийг харгалзан доор дурдсан хувиар мөнгөн шагналыг олгоно:

Багийн гишүүн	Нийт тоглосон хугацаанд хамаарах хувь	Олгох мөнгөн шагналын хувь
Тамирчин	50 - аас дээш	100
	50 - аас доош	50

2.5. Улсын аварга шалгаруулах тэмцээний жин, зайд оролцсон тамирчны тоо, өрсөлдөөний чанараас хамааран тамирчинд доор дурдсан хувиар мөнгөн шагнал олгоно:

Спортын их наадам, Улсын аварга шалгаруулах тэмцээн	Жин, зай, төрөл тус бүрт оролцсон тамирчны тоо		Олгох мөнгөн шагналын хувь
	Эрэгтэй	Эмэгтэй	
Насанд хүрэгчид	16-аас дээш	14-өөс дээш	100
	9-15	8-13	80
	8-аас доош	7-оос доош	60
Залуучууд, өсвөр үе	14-өөс дээш	12-оос дээш	100
	8-13	7-11	80
	7-оос доош	6-аас доош	60

Гурав. Улсын хэмжээний тэмцээн, наадамд мөнгөн шагнал олгоход тавих шаардлага

3.1. Тэмцээн зохион байгуулсан спортын холбоо нь тэмцээний тайлан, протоколыг тэмцээн дууссанаас хойш 21 хоногийн дотор Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

3.2. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь спортын холбоодоос ирүүлсэн тэмцээний протокол, тайланг хянаж, тамирчин, дасгалжуулагчдын мөнгөн шагналыг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

3.3. Дараах тохиолдолд мөнгөн шагналыг олгохгүй:



3.3.1. тэмцээний протокол, тайлан, тамирчинд олгох мөнгөн шагналтай холбоотой материалын бүрдэл дутуу, хугацаанд нь ирүүлээгүй;

3.3.2. өсвөр үе, залуучуудын тэмцээнд нас дарж орсон.

3.4. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага мөнгөн шагнал хүртсэн тамирчин, дасгалжуулагчийн талаарх мэдээллийн санг бүрдүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 6 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар
хот

Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16, 17.2, 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрмийг 1 дүгээр хавсралт, зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм, сангийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 110 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Д.ЦОГТБААТАР

Засгийн газрын 2018 оны 179 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16-д заасан Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан (цаашид



“Сан” гэх)-гийн хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

1.2. Сангийн үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Сангийн эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

2.1.1. улсын төсвийн хөрөнгө;

2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс өгсөн буцалтгүй тусламж, хандив.

2.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын төсвөөс Санд олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17.1-д заасныг баримтлан өмнөх онд хилийн чанадад эрх ашиг нь зөрчигдсөн иргэдийн тоо, дипломат төлөөлөгчийн газрууд, эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан монголын талын төв байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан төлөвлөнө.

2.3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу хянаж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөлд тусгана.

2.4. Сангийн хөрөнгийг төрийн сан дахь гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тусгай дансанд байршуулна.

Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Санг 7 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус Сангийн зөвлөл удирдана.

3.2. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Сангийн зөвлөлийн дарга байна. Сангийн зөвлөл нь дэд дарга, гишүүд, нарийн бичгийн даргатай байна.

3.3. Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байх бөгөөд 4-өөс доошгүй гишүүн оролцсоноор хурал хүчинтэйд тооцогдоно.



3.4. Сангийн зөвлөлөөр хэлэлцсэн асуудлыг Зөвлөлийн нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хурлын тэмдэглэлд Сангийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

3.5. Сангийн зөвлөл нь дараах эрх, үүрэг хүлээнэ:

3.5.1. Сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хяналт тавих;

3.5.2. тусламж авах, зардал олгуулахыг хүссэн өргөдлийг холбогдох Дипломат төлөөлөгчийн газар болон гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж (цаашид “Консулын газар” гэх)-ийн саналын хамт хянаж, хөрөнгө гаргах эсэхийг шийдвэрлэх;

3.5.3. шаардлагатай тохиолдолд гадаад, дотоодын байгууллага, иргэдээс нэмэлт мэдээлэл, тодруулга гаргуулж авах;

3.5.4. Сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын талаар гадаад харилцааны болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал тавих;

3.5.5. Сангийн хөрөнгийн зарцуулалт, иргэдэд үзүүлэх тусламжийн талаар Дипломат төлөөлөгчийн газар болон Консулын газарт чиглэл өгөх, гүйцэтгэлийг нь хянах;

3.5.6. олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, бусад сантай хамтран ажиллах;

3.5.7. Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан байгууллага, албан тушаалтанд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал хүргүүлж, шийдвэрлүүлэх.

3.6. Сангийн Ажлын албаны үүргийг Консулын газар гүйцэтгэнэ.

3.7. Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар нь Сангийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тусламж, зардал олгох арга хэмжээ авна.

3.8. Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар нь олгосон тусламж, зардлын талаар Сангийн зөвлөлд мэдээлэл өгч, холбогдох бичиг баримтыг хүргүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийг зарцуулах нөхцөл, шаардлага

4.1. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17.2-т заасан зориулалтаар зарцуулна.

4.2. Сангийн хөрөнгөөс хилийн чанадад байгаа Монгол Улсын төлбөрийн чадваргүй иргэнд тусламж, дэмжлэг үзүүлэх бөгөөд хилийн чанадад эрх ашиг нь зөрчигдсөн Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой зардлыг санхүүжүүлж болно.

4.3. Дараах тохиолдолд Сангийн хөрөнгөөс тусламж, зардал олгоно:

4.3.1. хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарил буюу чандрыг эх оронд нь авчрах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах;

4.3.2. хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;

4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэн эх орондоо буцах зардалгүй тохиолдолд нутаг буцаах;

4.3.4. гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;

4.3.5. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;

4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулах, хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;

4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Дипломат төлөөлөгчийн газраас эргэх;



4.3.8. гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан монголын талын төв байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл рүү орчуулах төлбөрийг гаргах.

4.4. Сангийн хөрөнгөөс гаргах тусламж, зардлын хэмжээг дараах байдлаар тодорхойлж тооцно:

4.4.1. гарсан бодит зардлаар;

4.4.2. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнийг эх оронд нь буцаах замын зардлыг тухайн үеийн хамгийн хямд, дөт замаар буцаах тээврийн зардлаар;

4.4.3. энэхүү дүрмийн 4.3.5-д заасан тусламжийн хэмжээг Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, тухайн улсын визийн хураамж, холбогдох Дипломат төлөөлөгчийн газрын зардлын гүйцэтгэлээр;

4.4.4. Энэхүү дүрмийн 4.3.8-д заасан орчуулгыг баталгаат орчуулгын товчоотой байгуулсан гэрээний үнийн дүн, төлбөрийн нэхэмжлэл, орчуулгын гүйцэтгэлийг үндэслэн эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ орчуулах жишиг үнийг баримтлан Сангийн хөрөнгөөс төлбөрийг олгоно.

4.5. Сангийн хөрөнгөөс гаргах тусламж, зардлын хэмжээг тухайн жилд Санд тусгагдсан хөрөнгийн хэмжээ болон Сангаас тусламж, зардал гаргуулахаар гаргасан өргөдлийн тоонд тулгуурлан нэг хүнд нэг удаа олгох тусламж, зардлын хэмжээг хязгаарлаж болно.

4.6. Энэхүү дүрмийн 4.3.5-д заасан тохиолдолд тухайн иргэн үндэсний гадаад паспорт эзэмших, хадгалах журмыг зөрчсөн байвал Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийг Сангийн хөрөнгөөс төлнө.

4.7. Энэхүү дүрмийн 4.3.4-т заасан тохиолдолд тухайн иргэнд эргэн төлөх нөхцөлтэйгөөр эх орондоо буцах зардал олгож болно. Нөхөн төлөх төлбөрийг эх орондоо ирснээс хойш тухайн санхүүгийн жилд багтаан Сангийн Ажлын албанд эргэн төлнө.

Тав. Өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх ажиллагаа

5.1. Сангийн хөрөнгөөс тусламж хүссэн өргөдлийг холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт буюу Консулын газарт гаргана.

5.2. Өргөдлийг дараах байдлаар гаргана:

5.2.1. иргэн биечлэн, эсхүл баталгаат шуудангаар;

5.2.2. эрүүл мэндийн буюу хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас өөрийн биеэр өргөдөл гаргах боломжгүй иргэний өргөдлийг түүний гэр бүлийн гишүүн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч;

5.2.3. энэхүү дүрмийн 4.3.1-д заасан тохиолдолд өргөдлийг түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгч, сонирхсон байгууллага болон консулын албан тушаалтан;

5.2.4. энэхүү дүрмийн 4.3.8-д заасан тохиолдолд тухайн байгууллагын албан бичиг.

5.3. Өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

5.3.1. үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх зэрэг иргэний харьяаллыг тодорхойлох баримт бичиг, эсхүл тэдгээрийн хуулбар;

5.3.2. тусламж үзүүлэх шаардлагатай болохыг нотлох суугаа орны цагдаа, шүүх эмнэлэг зэрэг зохих байгууллага, иргэний тодорхойлолт, мэдүүлгийн эх хувь, эсхүл хуулбар;

5.3.3. Шаардлагатай тохиолдолд энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4, 4.3.6-д заасан төлбөрийн чадваргүйг нотлох өрхийн ам бүл, орлогын хэмжээний талаар харьяалах баг, хороо, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагаас уламжлан авсан тодорхойлолт;

5.3.4. энэхүү дүрмийн 4.3.8-д заасан тохиолдолд эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан монголын талын төв байгууллагын албан бичиг, орчуулгын хуулбар болон холбогдох бусад баримт бичиг.

5.4. Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар нь 5.3.3-т заасан тодорхойлолтыг холбогдох байгууллагаас тухайн иргэний хүсэлтээр авч өгч болно.

5.5. Дипломат төлөөлөгчийн газар өргөдлийг хүлээн авч, энэхүү дүрмийн Дөрөвдүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягтлан, шаардлага хангаж байгаа бол өөрийн саналын хамт Сангийн Ажлын албанд цахим шуудангаар яаралтай хүргүүлнэ.

5.6. Консулын газарт хандан гаргасан өргөдлийг Сангийн Ажлын алба Сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэнэ.



5.7. Сангийн зөвлөл энэхүү дүрмийн Дөрөвдүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хянан шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацааг 5 хүртэл хоногоор сунгаж болно.

Зургаа. Сангийн хөрөнгийг зарцуулах

6.1. Сангийн Ажлын алба нь Сангийн зөвлөлийн шийдвэр гарсан даруйд Консулын газарт, эсхүл холбогдох Дипломат төлөөлөгчийн газарт Сангаас хуваарилагдсан хөрөнгийг олгох арга хэмжээ авна.

6.2. Дипломат төлөөлөгчийн газар нь Сангаас олгохоор шийдвэрлэсэн хөрөнгийг Сангийн ажлын Албаны зөвшөөрлөөр өргөдөл гаргагчид урьдчилан олгож болох бөгөөд гаргасан хөрөнгийг Сангийн Ажлын алба нөхөн хүргүүлнэ.

6.3. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

Долоо. Сангийн гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавих

7.1. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр гаргана.

7.2. Сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

7.3. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн хөрөнгийн зарцуулалтын жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлтийн хамт тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Шаардлагатай тохиолдолд Сангийн хөрөнгөөс олгосон тусламж, зардлын талаарх мэдээллийг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.



Засгийн газрын 2018 оны 179 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД
ТУСЛАХ САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Гадаад харилцааны сайд.
Дэд дарга	-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга.
Гишүүд:	-Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга; -Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга; -Улсын дээд шүүхийн Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга (зөвшилцсөнөөр); -Улсын ерөнхий прокурорын газрын Гадаад харилцаа, эрх зүйн туслалцааны хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр).
Нарийн бичгийн дарга	-Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2018 оны 9 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим
заалт Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн
эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Чинбат даргалж, гишүүн Ш.Цогтоо /илтгэгч/, Д.Солонго, Б.Буяндэлгэр, Ц.Нанзаддорж нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны танхимд нээлттэй хийв.



Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Ш.Алтангадас, Ө.Эрдэнэ-Очир, Т.Мөнх-Эрдэнэ, Д.Гантөмөр нар оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Тавьдугаар зүйлийн 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны оршин суугч, иргэн Ө.Эрдэнэ-Очир, Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Ш.Алтангадас нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...” гэж заасны дагуу хууль бусаар хохирсон гэдэг нь шүүхээр тогтоогдсон бол хохирол учруулсан этгээдээс нөхөн төлүүлж зөрчигдсөн эрх, ашиг сонирхлоо нөхөн сэргээлгэх эрхийг баталгаатай эдлэхээр заажээ. Иргэний “шүүхэд гомдол гаргаж хохирлоо нөхөн төлүүлэх” эрх нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хангаж хамгаалах гол баталгаа болж байдаг билээ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “18.1.1. энэ хуулийн 6.2.1, 6.2.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 4 жил; 18.1.2. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.3. энэ хуулийн 6.2.4, 6.2.5-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.4. энэ хуулийн 6.2.6-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 2 жил.” гэж заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дээрх зохицуулалт нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад

этгээд заавал биелүүлнэ. ..." гэж заасныг зөрчиж "шүүхийн шийдвэр заавал биелэх" шинж чанарыг үгүйсгэж тодорхой хугацаа өнгөрсний дараа шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх хууль зүйн нөхцөлийг үүсгэжээ.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байж болох нөхцөл боломжийг хуулиар бий болгох нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалалтгүй болгож төр Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан үүргээ зөрчсөн гэж үзэж байгаа тул уг асуудлыг хянан шийдвэрлэж дүгнэлт гаргаж өгнө үү." гэсэн агуулгатай мэдээлэл гаргажээ.

Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Т.Мөнх-Эрдэнэ, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Г.Орхон нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй байхаар тусгажээ. Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ..." гэж заасныг зөрчсөн байна.

Аливаа этгээдийг "хууль бусаар бусдад хохирол учруулсан" хэмээн шүүх тогтоосон тохиолдолд бусдад хохирол учруулсан этгээд хохирлыг сайн дураараа нөхөн төлөх үүрэгтэй ба ийнхүү сайн дураар нөхөн төлөөгүй тохиолдолд гүйцэтгэх хуудсыг үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэж, эрх нь зөрчигдсөн этгээдийн хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг албадан гүйцэтгэдэг журамтай.

Өөрөөр хэлбэл, нэг талаас шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр нь зөрчигдсөн эрхийг бодитоор сэргээх баталгаа, нөгөө талаас иргэнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор эрх бүхий байгууллага албадлага



хэрэглэх үйл явц бөгөөд учирсан хохирлоо нөхөн төлүүлэх нь иргэний үндсэн эрх болж, ийнхүү Үндсэн хуулиар баталгаажсанд оршиж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь иргэний үндсэн эрхийг хангах зорилготой байтал тодорхой хугацаа өнгөрсний дараа эл шийдвэрийг биелүүлэхгүй байхаар хуульчилсан нь шүүхийн шийдвэр заавал биелэгдэх зарчим хийгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндсэн зорилгод нийцэхгүй байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дээр дурдсан маргаан бүхий зүйл, заалт нь Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн гэж үзэж байна.” гэсэн агуулга бүхий мэдээлэл гаргажээ.

Гурав. Нийслэлийн Баянгол дүүргийн 18 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Гантөмөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Иргэний хуулийн эрх зүйн зохицуулалтын дагуу эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, зөрчигдөхөөс өмнөх байдлыг сэргээх, хүлээсэн үүргийг гүйцэтгүүлэх, учруулсан хохирлыг арилгуулах шаардлага бүхий нэхэмжлэл, гомдлыг шүүхэд гарган шийдвэрлүүлдэг. Шүүхээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь түүний үр дүнд гарах шийдвэрийг биелүүлэх ажиллагаатай салшгүй холбоотой байдаг.

Энэ утгаараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зүйл, заалтад “хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь саад учруулсан этгээдэд хууль ёсны хариуцлага хүлээлгэнэ”, “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг иргэн, хуулийн этгээд заавал биелүүлнэ”, “Шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасны үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ” гэж хуульчилжээ. Дээрхээс үзэхэд, шүүхийн шийдвэр нь хуулийн адил заавал биелэгдэх ёстой.

Нөгөө талаас бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага нь төрийн албадлагаар хэрэгждэг бөгөөд заавал биелэгддэг байх ёстой. Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлд тодорхой хугацаа өнгөрсөн бол шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхгүй гэх зохицуулалтыг оруулсан нь Шүүхийн эрхэм зорилго болох “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох, хууль дээдлэх, шударга ёс, ардчилсан ёсыг бэхжүүлэх”-ийг үгүйсгээд зогсохгүй нийгмийн дэг журмыг зөрчиж байна.

Шүүхийн шийдвэрийн хариуцагч буюу төлбөр төлөгч нь шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв биелүүлэхгүй

бол хуульд заасны дагуу албадан гүйцэтгүүлэх үр дагавар үүснэ. Ийнхүү хуулиар хариуцагч, төлбөр төлөгчид шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлэх боломжийг олгож байгаа нь өөрийн санхүүгийн эх үүсвэрийн байдалтай уялдуулан хуваарь гарган төлбөрийг төлөх, өөрийн ямар хөрөнгийн аль хэсгээс төлбөрийг барагдуулах тухай шийдвэрийг гаргах боломжийг олгож байгаа бөгөөд энэ нь хариуцагч, төлбөр төлөгчийн өөрийн эд хөрөнгийг өмчлөх эрхийг баталгаажуулах боломжийг олгож байдаг. Нөгөө талаас нь авч үзвэл, төлбөр авагч болон төлбөр төлөгч нарын хооронд шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон өр төлбөрийг хэрхэн төлөх, авах талаар харилцан тохиролцох боломжийг олгохын зэрэгцээ хэрэв уг тохиролцоо зөрчигдвөл төлбөр авагчид түүний хүсэлтээр шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломж хэзээд хадгалагдаж байх агуулгыг илэрхийлдэг. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаар шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсноос хойш тодорхой хугацаа өнгөрвөл шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэхгүй тухай заалт нь Үндсэн хуулиар олгогдсон бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг шууд зөрчиж байна.

Нийгэмд шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх зарчим алдагдах жишиг тогтоно. Тодруулбал, нэг талд төлбөр төлөх үүрэг бүхий этгээд нь хуульд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгүүлэхгүй байх боломжит хугацааг хүлээх, цаг хожихын тулд төрөл бүрийн худал нөхцөл байдлыг зориудаар бий болгох ингэснээр хууль, шүүхийн шийдвэрийн дагуу бусдад төлөх өр төлбөрийн үүргээс чөлөөлөгдөх, уг дүнгээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих нөгөө талд нь хууль, шүүхийн шийдвэрийн дагуу өр төлбөрийг авах эрх бүхий этгээд нь хуулийн мухардалд орно.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн үүднээс авч үзвэл, хүмүүс бие биенээ харилцан ойлголцож, өөр өөрийн ухамсар ойлголтын түвшнээс хамааран нийгмийн болон бусдын харилцааг ойлгож, тэдгээрт боломж ухаарал, итгэл олгох бөгөөд /зарим тохиолдолд төлбөр авагч, төлбөр төлөгч нар нь ойр дотнын ах дүү, хамаатан садан байх тохиолдол бий/ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтаар шүүхийн шийдвэрийг шууд албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг гаргахаас өөр сонголтыг олгохгүй байна.

Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулан Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж хуульчилжээ.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалт нь тодорхой хугацаа өнгөрсөн бол иргэний хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх төрийн хүлээсэн үүргийг шууд үгүйсгэж байгаа ба уг хугацаа өнгөрсний дараа төлбөр авагч иргэн өөрийн зөрчигдсөн эрхийг хэрхэн сэргээлгэх, өр төлбөрийг хэрхэн авах талаар мухардмал байдалд оруулж байна.

Тодруулбал, тухайн асуудлаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй болсон, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүсэлтийг хүлээн авахгүй, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх боломжгүй болсон иргэн өөрөө төлбөр төлөгчийн хойноос хөөцөлдөж төлбөрөө авахаас өөр сонголт үйлдэхгүй байна. Төлбөр төлөгч эд хөрөнгөө нуусан, оршин суугаа газраа өөрчилсөн тохиолдолд иргэн түүнийг мэдэх, илрүүлэх боломжгүй бөгөөд энэ ажиллагааг зөвхөн эрх бүхий байгууллага тусгай журмын дагуу гүйцэтгэх эрхтэй ба үүнийг гүйцэтгэх ажиллагаа хэмээн нэрлэдэг. Иймд төлбөр төлөгчийн хойноос өөрөө хөөцөлдөж төлбөрөө гаргуулан авах гэдэг нь боломжгүй зүйл юм.

Иймд дээрх үндэслэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн агуулгатай мэдээлэл ирүүлсэн байна.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд иргэний болон захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэж болохгүй хугацааг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн төрөл, агуулгаас хамааран харилцан адилгүй тогтоосон. Хууль тогтоогч хууль заасан дээрх хугацаа өнгөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй байхаар хуульчлаагүй, өөрөөр хэлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт заасан хугацаа өнгөрсөн ч хуульд /18.2-18.7, 124.2-124.4/ заасан үндэслэлээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хугацааг сэргээх, шинээр тоолох тухай зохицуулалтыг тодорхой тусгасан нь төлбөр авагчид шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлт гаргах, зөрчигдсөн эрхээ сэргээн эдлэх хангалттай боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчийн буруугаас буюу төлбөр төлөгч оргон зайлсан, эсхүл эд хөрөнгөө нуун далдалсан үйлдлийн улмаас

шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацаа дууссан тохиолдолд уг хууль бус үйлдэл үргэлжилсэн хугацааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хүсэлт гаргах хугацаанд оруулахгүй талаарх заалт хуульд тусгагдсан байгаа нь төлбөр төлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас төлбөр авагчийн эрх ашиг дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлсэн механизм юм. Захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд мөн дээрхтэй адил зохицуулалтыг нэгэн адил хуульчилж өгсөн.

Шүүхээс иргэний зөрчигдсөн эрх ашиг, сонирхлыг сэргээх, учирсан хохирлыг барагдуулах талаарх хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарсны дараа хуульд зааснаас бусад тохиолдолд гагцхүү төлбөр авагчийн хүсэл, сонирхлыг үндэслэж буюу уг шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэх хүсэлтийг төлбөр авагч шүүхэд гаргаж байж гүйцэтгэх хуудсыг шүүхээс олгосноор шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдах нөхцөл бүрддэг.

Өөрөөр хэлбэл, иргэний эрх зүйн маргааны талууд өөрсдийн зөрчигдсөн эрхээ сэргээлгэх үүргийг хүлээж, нотлох баримт цуглуулах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлэх, эс хэрэгжүүлэхээ өөрөө бие даан хэрэгжүүлдгийн нэгэн адил дээр дурдсанчлан гарсан шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхээр хүсэлт гаргах эсэх нь мөн өөрсдийнх нь эрхийн асуудал тул уг эрхээ хэрэгжүүлэх хугацааг ямар нэгэн хязгааргүйгээр олгох нь төлбөр төлөгчийн эрхийг зөрчиж хугацаагүй төлбөр төлөгч байхад хүргэх бөгөөд 10 жил, 20 жилийн өмнө ч гарсан шүүхийн шийдвэрийг үндэслэн албадлагын арга хэмжээ явуулж, төлбөр төлөгчийн эрхэд халдах эрсдэлийг бий болгох сөрөг үр дагавартай юм.

Ийнхүү хугацааг зааж зохицуулж өгснөөр төлбөр төлөгч хуульд заасан хугацааны дотор буюу шийдвэр гарсан даруйд түүнийг биелүүлэх хүсэлт гаргаснаар шийдвэрийн биелэгдэх боломж нэмэгдэх, түүнчлэн хэдэн ч жилийн өмнө гарсан шийдвэрийг албадан биелүүлэхээр хүсэлт гаргах, ажиллагаа явуулах, эрх зүйн ач холбогдлоо алдсан, хугацаа алдсаны улмаас эд хөрөнгө байхгүй болсон буюу биелэгдэх боломжгүй шийдвэрийг биелүүлэхээр цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарахгүй байх нөхцөл боломж бүрдсэн. Нөгөө талаас, хугацаа заахгүй байх нь төлбөр авагчид хэт давуу байдал бий болгож ямар нэгэн цаг хугацааны хязгааргүйгээр шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаа үүсгэх боломж, нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар иргэн бүрийн шүүхийн журмаар хөндөгдсөн эрхээ сэргээн эдлэх нэхэмжлэл гаргах эрхийг баталгаажуулсантай зэрэгцэн иргэн өөрт олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрхийг зөрчихгүй байх зарчмыг ч мөн адил тодорхойлсон байдаг. Үүнтэй уялдуулан хууль тогтоогч шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх



нөхцөл, боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ иргэн бүрд төлбөр авагч, төлбөр төлөгч эсэхээс үл хамааран адил тэгш эрх, эрхээ хамгаалах механизмыг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Дээр дурдсаныг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...", Арван ес дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж тус тус заасныг зөрчөөгүй." гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн агуулга ёсоор хуулийн хүчин төгөлдөр болсон аливаа шүүхийн шийдвэрийг заавал биелүүлэх зарчим үйлчлэх бөгөөд холбогдох этгээд шүүхийн шийдвэрийг сайн дураар биелүүлээгүй бол эрх бүхий байгууллага албадан биелүүлэх боломж, баталгааг хуулиар бүрдүүлсэн байх учиртай. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг батлан гаргажээ.

2. Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг албадан биелүүлэх буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах үндэслэл нь төлбөр авагч, нэхэмжлэгч этгээдийн хүсэлтийн дагуу шүүхээс олгосон гүйцэтгэх хуудас байдаг. Өөрөөр хэлбэл, төлбөр авагч, нэхэмжлэгч этгээдийн хүсэлтийн үндсэн дээр шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэн явуулдаг болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй буюу түүнийг албадан гүйцэтгэхгүй байх үр дагавар бүхий зохицуулалтыг

хуульчилсан байна. Гэсэн хэдий ч энэ хугацаанд төлбөр авагч болон нэхэмжлэгч нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх талаарх хүсэлтээ шүүхэд гаргах эрхтэй байхаас гадна уг хугацааг хэтрүүлсэн боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэж болох тодорхой тохиолдлуудыг мөн тусгажээ.

Тодруулбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-18.7 дахь хэсэг, 124 дүгээр зүйлийн 124.2-124.4 дэх хэсэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлсэн болон уг хугацаанд төлбөр төлөгч гүйцэтгэх баримт бичигт заасан шаардлагыг биелүүлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан зэрэг хэд хэдэн тохиолдолд тухайн хугацааг сэргээн тоолох, шинээр тоолохоор тусгасны зэрэгцээ тоолохгүй байх үндэслэлийг мөн хуульчилсан байна.

Иймд иргэний болон захиргааны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагад хандах иргэний эрх, хугацаа, тухайн хугацааг сэргээлгэх үндэслэл зэргийг тус хуулийн холбогдох зохицуулалтаар тогтоосон байх тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзэх үндэслэлгүй байна.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх хугацааны талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох буюу тухайн хугацааг сэргээн тоолох, шинээр тоолох, тоолохгүй байх үндэслэлийг дэлгэрүүлэн тогтоох шаардлага байхыг үгүйсгэхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь хугацаа өнгөрсөн тохиолдолд иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй: 18.1.1.энэ хуулийн 6.2.1, 6.2.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 4 жил; 18.1.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2.3-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.3.энэ хуулийн 6.2.4, 6.2.5-д заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 18.1.4.энэ хуулийн 6.2.6-д заасан



шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 2 жил.”; 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол дараахь хугацаа өнгөрсөн тохиолдолд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэхгүй: 124.1.1. энэ хуулийн 6.3.1, 6.3.3, 6.3.4-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 3 жил; 124.1.2.энэ хуулийн 6.3.2-т заасан шийдвэр хуулийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан.” гэж заасан нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...”, Арван ес дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Н.ЧИНБАТ

**Ш.ЦОГТОО
Д.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Ц.НАНЗАДДОРЖ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

Индекс: 200003